

БАТЛАВ
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.МӨНХЗУЛ

[Signature]

ATA12944 9132155 9124070803

Улаанбаатар хот

2025 оны 10 сарын 19-ний өдөр

СУРГАЛТЫН АГУУЛГА БОЛОВСРУУЛЖ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц болон холбогдох хууль, тогтоомжийн үндсэн агуулга, зарчим болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, төрийн үүрэг, мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхжуулахад оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад 107.2 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.1 хувийг эзэлж байна.

Түүнчлэн нийт хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 11.8 хувь буюу 12.7 мянга нь 0-18 насны хүүхэд, 82.0 хувь буюу 87.9 мянган нь 15-65 хүртэлх хөдөлмөрийн насны иргэд байдаг. Хөдөлмөрийн насны иргэдийн 16.9 мянга нь хөдөлмөр эрхэлж, үүнээс 5.9 мянга нь төрийн албанд ажилладаг, 83 орчим хувь нь ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй гэр бүлийн хүмүүс ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаагаас ядууралд өртөх нөхцөл үүсэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, нийгмийн хамгааллын асуудлыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд эрхлэхээр заасны дагуу 2025 оны хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 64.5 мянган иргэн нийгмийн даатгалын сангаас болон 55.4 мянган иргэн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ авч байна.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийг боловсруулж, хэрэгжүүлэх болон өдөр тутам үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төрийн албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, чадавхыг сайжруулах сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

ХОЁР. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Гэр бүл, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц болон холбогдох хууль, тогтоомжийн үндсэн агуулга, зарчим болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, төрийн үүрэг, мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын төлөвлөгөө, сургалтын агуулгыг бэлтгэн сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Багцад тусгагдсан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажлыг гүйцэтгэнэ.

Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Агуулга	Төсөв (мян.төг)	Хугацаа
1	Сургалтын агуулга (тэнхим, цахим хэлбэрээр)	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, төрийн үүрэг, эрх зүйн зохицуулалт - Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар - Мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт - Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх аргачлал - Хүртээмжийг бий болгох шалгуур үзүүлэлтүүд - Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн онцлог - Сургалтын үнэлгээний асуумж	6,000.0	XI/01-XI/06
2	Дасгал ажлын агуулга (тэнхим, цахим хэлбэрээр)	- Хүртээмжтэй төрийн үйлчилгээг таниулах кейс - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх аргачлал, хүртээмжийг бий болгох шалгуур үзүүлэлт, эмпати ба симпати - Хамрагдах хугацаа, давтамж	2,000.0	XI/07-XI/11
3	Сургалтын төлөвлөгөө боловсруулах	Боловсруулсан сургалтын агуулгаар сургалт зохион байгуулах төлөвлөгөөг байршлал, хугацаа, сургалтын хэлбэрээр гаргах	1,000.0	XI/12-XI/14
4	Сургалт зохион байгуулах зардлын тооцоолол	- Боловсруулсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэнэ. - Зардлыг тооцохдоо батлагдсан норм, нормативт үндэслэнэ.		XI/14
5	Явцын тайлан ирүүлэх	Боловсруулсан сургалтын агуулга, төлөвлөгөө, зардлын тооцоолол		XI/14
6	Танхимын сургалтыг зохион байгуулах	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчид болон 3 аймаг, 6 дүүргийн 200 төрийн албан хаагчийг хамруулах	8,000.0	XI/15-XII/15
7	Цахим сургалт зохион байгуулах	18 аймаг, 3 дүүргийн 600 төрийн албан хаагчийг хамруулах	2,000.0	
8	Эцсийн тайлан ирүүлэх	Сургалтын үйл ажиллагааг нэгтгэсэн тайланд тусгасан байх		XII/20

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь баг, хувь хүн байж болно.

Туршлага:	Ур чадвар:
- Ижил төстэй 5-аас доошгүй сургалтыг амжилттай гүйцэтгэсэн туршлагатай; - Хөгжлийн бэрхшээлтэй хүний чиглэлээр ажилласан туршлагатай; - Мэдээлэл цуглуулах, шинжлэх, боловсруулах ажлын туршлагатай;	- Сургалт зохион байгуулах чадвартай; - Баримт бичиг боловсруулах чадвартай;

- Дүн шинжилгээний баримт бичиг, тайлан, илтгэл бэлтгэх, илтгэх чадвартай - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр бодлого боловсруулах ажилд оролцож байсан бол давуу тал болно. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол давуу тал болно.	- Уулзалт, хэлэлцүүлэг чиглүүлэх, зохион байгуулах чадвартай.
---	---

ТАВ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Тус яамны Гэр бүлийн бодлогын газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗУРГАА.САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил хамгааллын чиглэлээр туссан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ зардлаас санхүүжүүлнэ. Арга хэмжээний төлбөр нь 19,000,000 /арван есөн сая/ төгрөг байна.

Явцын тайлан ирүүлснээр төлбөрийн 50 хувийг, эцсийн тайланг хүлээлгэн өгсний дараа, хянаж үлдэгдэл төлбөрийг төлнө.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд төлбөрт бүх зардал, татвар, хураамж багтсан болно.

ДОЛОО.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Ажил гүйцэтгэгчийн анкет, (баг бол багийн гишүүн бүр);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбар;
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга;
- Албан хүсэлт;
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг.

---oOo---